



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

---

Адал явдалт аялал жуулчлал- Оролцогчдод  
өгөх мэдээлэл

MNS ISO 21103:2021

Албан хэвлэл

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

Улаанбаатар хот

2021 он



**ХУВИЛАН ОЛШРУУЛАХ ЭРХ НЬ ХАМГААЛАГДСАН.**

Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын нийт стандарт болон тэдгээрийг үндэсний болгон баталсан хувилбарыг хуулбарлан олшруулах эрх нь хамгаалагдсан. Иймд өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд Стандартчиллын төв байгууллагаас бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр ISO стандартын болон тэдгээрийг үндэсний болгон баталсан хувилбарын аливаа хэсгийг электрон, механик, дүрс буулгах зэрэг аливаа аргаар хуулбарлан олшруулах, ашиглахыг хориглоно. Зөвшөөрөл хүссэн хүсэлтийг

Стандартчилал, хэмжил зүйн газар  
Энхтайваны өргөн чөлөө 46А  
Улаанбаатар, 13343, Монгол Улс  
Э-шуудан: [standardinform@masm.gov.mn](mailto:standardinform@masm.gov.mn)  
Вэб хуудас: [www.estandart.gov.mn](http://www.estandart.gov.mn)

хаягаар эсхүл Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын дараахь хаягаар хүлээн авна:

ISO copyright office  
Case postale 56 CH-1211 Geneva 20  
Tel: + 41 22 749 01 11  
Fax: + 41 22 749 09 47  
E-mail: [copyright@iso.org](mailto:copyright@iso.org)  
Web: [www.iso.org](http://www.iso.org)

Агуулга	Хуудас
<b>Өмнөх үг</b> .....	IV
<b>Оршил</b> .....	V
<b>1</b> Хамрах хүрээ .....	1
<b>2</b> Нэр томъёо ба тодорхойлолт .....	1
<b>3</b> Мэдээллийн харилцаа .....	2
<b>4</b> Адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагаа эхлэхээс өмнө өгөх мэдээлэл .....	2
<b>4.1</b> Адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагаа эхлэхээс өмнө өгөх мэдээллийн зорилго .....	2
<b>4.2</b> Урьдчилсан захиалгын мэдээлэл .....	3
<b>5</b> Адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагааны явцад өгөх мэдээлэл .....	5
<b>5.1</b> Үйл ажиллагааны явцад өгөх мэдээллийн зорилго.....	5
<b>5.2</b> Үйл ажиллагааны явцад өгөх мэдээлэл.....	5
<b>6</b> Адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагааны дараа өгөх мэдээлэл .....	5
<b>6.1</b> Үйл ажиллагааны дараа өгөх мэдээллийн зорилго.....	5
<b>6.2</b> Үйл ажиллагааны дараа өгөх мэдээлэл.....	5
Ном зүй.....	7

## Өмнөх үг

ОУСБ (Олон улсын стандартчиллын байгууллага) нь Үндэсний стандартчиллын байгууллагуудын (ОУСБ-ын гишүүн байгууллагууд) дэлхий дахины холбоо юм. Олон улсын стандарт боловсруулах үйл ажиллагаа нь ОУСБ-ын техникийн хороогоор дэмжигддэг бөгөөд тухайн техникийн хорооны хариуцах асуудлыг сонирхсон гишүүн байгууллага бүр уг хороонд төлөөлөлтэй байх эрхтэй. ОУСБ-тай харилцаа бүхий Засгийн газрын болон Засгийн газрын бус олон улсын байгууллагууд уг ажилд мөн оролцоно. ОУСБ нь цахилгаан техникийн стандарт боловсруулахдаа Олон Улсын Цахилгаан Техникийн Комисстой (ОУЦТК) нягт хамтран ажилладаг.

Энэхүү баримт бичгийг боловсруулах болон цаашид нэмэлт өөрчлөлт оруулахаар бол ОУСБ/ОУЦТК-ын Удирдамжийн 1 дугаар хэсэгт заасан дүрмийн баримтална. Ялангуяа ОУСБ-ын ялгаа бүхий цувралуудын баталгаажуулалтад өөр өөр төрлийн шалгуур үзүүлэлт шаардлагатайг энд онцлон тэмдэглэх нь зүйтэй. Стандартыг ОУСБ/ОУЦТК-ын Удирдамжийн 2 дугаар хэсэгт өгсөн дүрмийн дагуу боловсруулав ([www.iso.org/directives](http://www.iso.org/directives) сайтаас үзнэ үү).

Энэхүү баримт бичгийн зарим хэсэг зохиогчийн эрхэд хамаарч болохыг анхаарах хэрэгтэй. ОУСБ зохиогчийн эрхэд хамаарах аливаа асуудлыг тогтоохыг хариуцахгүй. Уг баримт бичгийг боловсруулах явцад гарсан аливаа зохиогчийн эрхийн талаар оршил хэсэгт ба/буюу патентын мэдүүлгийн ИСО-ийн жагсаалтад тэмдэглэгдсэн болно ([www.iso.org/patents](http://www.iso.org/patents) сайтаас үзнэ үү).

Энэхүү баримт бичигт хэрэглэгдсэн аливаа худалдааны нэр нь хэрэглэгчдэд ашиглахад нь дөхөмтөйг бодолцсон бөгөөд эдгээрийг дэмжиж буй хэрэг биш юм.

ОУСБ-ын тусгай нэр томъёоны үтгын тайлбар, тохирлын үнэлгээтэй холбоотой хэллэгүүд, түүнчлэн Худалдаан дах техникийн саад тотгорын хэлэлцээр дэх Дэлхийн Худалдааны Байгууллагын (ДХБ) зарчмуудыг ОУСБ-аас баримталж буй талаарх мэдээллийг дараах сайтаас харна уу: URL: Foreword - Supplementary information

Энэ баримт бичгийг ОУСБ-ын 228 дугаар аялал жуулчлалын үйлчилгээний техникийн хороо (ISO/TC 228, *Tourism and related services*) хариуцна.

## Оршил

### 0.1 Адал явдалт аялал жуулчлал

Адал явдалт аялал жуулчлал бол ач холбогдол нь улам бүр өсөн нэмэгдэж буй даян дэлхийн үйлдвэрлэл юм. Ашгийн ба ашгийн бус эсвэл буяны төлөө байсан ч адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагаа нь угаасаа эрсдэл, сорилын хүлээн зөвшөөрөхүйц элементүүдтэй байдаг. Эрсдэлтэй байх нь урам зориг өгдөг хэдий ч аюулыг бас дагуулдаг. Урам зориг, таашаалыг хамгийн дээд хэмжээнд байлгахын тулд адал явдалт аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчид нь үйл ажиллагаагаа аль болох аюулгүй байхаар ажиллах хэрэгтэй. Олон улсын энэ стандарт болон ISO/TR 21102, ISO 21103 нь адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагааг практикт аль болох аюулгүй байдлаар төлөвлөх, харилцах, хүргэж үйлчлэхэд адал явдалт аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчдэд үндэс болно. ISO/TR 21102, ISO 21103 болон олон улсын энэхүү стандартыг оновчтой хэрэгжүүлснээр хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлэгч болон тэдний үйл ажиллагааны тухай мэдээлэл өгч сонголт хийхэд нь тусална.

### 0.2 Адал явдалт аялал жуулчлалын стандартууд

Адал явдалт аялал жуулчлалын стандартуудын зорилго нь аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ба оролцогчдод хүргэх харилцааны хамгийн энгийн шаардлагуудыг тогтоох явдал юм. Мөн адал явдалт аялал жуулчлалын янз бүрийн асуудалд хамаарах дараах бие даасан хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Энэхүү олон улсын стандарт нь адал явдалт аялал жуулчлалын байгууллага аюулгүй байдлын үүднээс үйл ажиллагаагаа хэрхэн удирддаг болохыг тодорхойлдог.
- ISO/TR 21102 нь адал явдалт аялал жуулчлалын үйлчилгээг удирдагчдын чадамжийн хамгийн доод шаардлагыг тодорхойлно;
- ISO 21103 нь аюулгүй байдлыг хангахын тулд оролцогчдод болон оролцож болох хүмүүст үйл ажиллагааны өмнө, тухайн үед болон дараа нь хүргэх хамгийн бага мэдээллийг зааж өгсөн болно.

### 0.3 Олон улсын энэхүү стандартын зорилго

Энэхүү олон улсын стандарт нь сонирхогч талууд болон боломжит оролцогчдод үзүүлэх адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагааг багтаасан үйлчилгээний гэрээний талуудад хамаарах мэдээллийн ерөнхий шаардлагуудыг тодорхойлдог. Оролцогчдод энэхүү олон улсын стандартад нийцсэн үнэн зөв мэдээлэл өгөх нь оролцогч болон оролцож болох хүмүүст үйл ажиллагааны явцад ба дараа, захиалгаа хийх үед нь үйл ажиллагаануудын талаар мэдээлэлтэй байж сонголтоо хийхэд нь туслах болно.

Энэхүү мэдээлэл нь оролцогчид эрсдлийг ойлгож, тоног хэрэгсэл гэмтэх эсвэл хүмүүсийг гэмтээх эрсдлийг бууруулахын тулд бэлтгэгдсэн эсэхийг баталдаг. Энэ нь аюулгүйн дадлага туршлагыг нэмэгдүүлдэг. Аялал жуулчлалын хамрах хүрээнд адал явдалт аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч нар мэдээллийн эрсдлүүдийг анхаарч үзэх хэрэгтэй, хэлний ялгаатай байдал нь хүмүүс мэдээллийг буруу тайлбарлахад хүргэж болзошгүй. Үйлчилгээ үзүүлэгч нар адал явдалт үйл ажиллагааны зайлшгүй эрсдлүүдийг мэдээллэх хэрэгтэй. Үр дүнтэй харилцааг хангахын тулд оролцогчдод өгөх мэдээлэл нь оролцогчдын хэрэгцээг тодорхойлж ямар мэдээлэл оролцогчдод хэрэгтэйг үйлчилгээ үзүүлэгчдэд зааж өгдөг.

## Ангилалтын код

Адал явдалт аялал жуулчлал- Оролцогчдод өгөх мэдээлэл	MNS ISO 21103:2021
Adventure tourism — Information for participants	ISO 21103: 2014

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны . дүгээр сарын . -ны өдрийн С/.. дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь 2021 оны . дугаар сарын . -ны өдрөөс эхлэн хүчинтэй.

**1 Хамрах хүрээ**

Энэхүү олон улсын стандарт нь адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагааны өмнө, явцад, дараа оролцогчдод өгөх мэдээлэлд тавих хамгийн энгийн шаардлагуудыг тодорхойлно.

Энэхүү олон улсын стандартыг газарзүй, нийгэм соёлын янз бүрийн орчинд үйл ажиллагааг өөр өөр төрөл, хэмжээгээр явуулж буй үйлчилгээ үзүүлэгчид ашиглаж болно.

**2 Нэр томъёо ба тодорхойлолт**

Энэ баримт бичигт дараах нэр томъёо тодорхойлолтыг хэрэглэнэ.

**2.1 Адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагаа**

аялал жуулчлалын зорилгоор адал явдалт аяллын үйлчилгээ үзүүлэхэд тодорхой хэмжээний заавар, удирдамж болон мөн албан ёсоор хүлээн зөвшөөрсөн эрсдлийн (2.8) элемент бүхэлдээ багтана.

ТАЙЛБАР: Эрсдлийн хүлээн зөвшөөрсөн элемент гэж холбогдох эрсдлийн талаар адал явдалт оролцогчдын хамгийн энгийн ойлголтыг хэлнэ.

**2.2 Бэрхшээлийн түвшин**

Адал явдалт аяллын үйл ажиллагаанд оролцох үед шаардлагатай техник үр чадвар, уур амьсгал эсвэл гадаргын хэлбэр, өндөрлөг зэрэг хүчин зүйлсээс үүдэлтэй тулгарах бие махбодийн болон сэтгэл зүйн хүндрэлийн зэрэглэл

**2.3 Хөтөлбөр**

Хугацаа, байршил, үйл ажиллагаа зэрэг адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагаа (2.1)-ны бүрдэл хэсгүүдийг багтаасан тайлбар бичвэр

**2.4 Оролцогч**

адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагаанд (2.1)-д оролцож буй удирдлагын багийн гишүүн биш хувь хүн

1-Р ТАЙЛБАР: Оролцогчийг "үйлчлүүлэгч", "хэрэглэгч" эсвэл үүнтэй төстэйгээр нэрлэж болно.

2-Р ТАЙЛБАР: Удирдлагын баг хэд хэдэн удирдагчаас бүрдэнэ.

**2.5 Адал явдалт аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч**

адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагаа (2.1)-ны үйлчилгээг үзүүлэх асуудлыг бүхэлд

нь хариуцах хувь хүн буюу *байгууллага*

ТАЙЛБАР: Адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагаанууд нь төлбөргүй эсвэл дараа төлбөртэй хийгдэж болно.

## **2.6 Гуравдагч талын үйлчилгээ үзүүлэгч**

Адал явдалт аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчид үйлчилгээ үзүүлж буй гадны байгууллага буюу хувь хүн

## **2.7 Чөлөөт цаг**

Адал явдалт аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчийн гэрээний үүрэгт тодорхойлсноос бусад адал явдалт аяллын үйл ажиллагаа үргэлжлэх үед гарсан хугацаа

## **2.8 Эрсдэл**

тодорхой бус байдлын үр нөлөө

1-Р ТАЙЛБАР: Үр нөлөө бол хүлээлтийн хазайлт - эерэг эсвэл сөрөг.

2-Р ТАЙЛБАР: Тодорхой бус байдал бол үйл явдал, түүний үр дагавар эсвэл боломжийн талаарх ойлголт эсвэл мэдлэгтэй холбоотой мэдээллийн хэсэгчлэсэн ч гэсэн хомсдолын байдал юм.

3-Р ТАЙЛБАР: Эрсдэл нь болзошгүй *үйл явдлууд* (ISO зааварчилгаа 73:2009, 3.5.1.3 д тодорхойлсноор), ба *үр нөлөө* (ISO зааварчилгаа 73:2009, 3.6.1.3 д тодорхойлсноор) эсхүл тэдгээрийн нийлбэрээр ихэвчлэн тодорхойлдогдоно.

4-Р ТАЙЛБАР: Эрсдэл нь үйл явдлын (нөхцөл байдлын өөрчлөлтийг багтаан) үр дагавар ба боломжуудын (ISO зааварчилгаа 73:2009, 3.6.1.3 д тодорхойлсноор) илрэлийн нийлбэрээр ихэвчлэн илэрхийлэгддэг.

## **3 Мэдээллийн харилцаа**

Оролцогчтой харилцах харилцаа нь үнэн зөв, ойлгомжтой байх ёстой. Оролцогчидтой харилцахдаа адал явдалт аяллын үйлчилгээ үзүүлэгч нар дараахь зүйлийг анхаарч үзнэ: Үүнд: оролцогчдын

- a) Эх хэл;
- b) Бичиг үсэгт тайлагдсан байдал;
- c) Яриа, сонсгол, харааны бэрхшээлтэй байдал.

Мөн түүнчлэн, адал явдалт аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч хаана ямар хэлбэрээр (хэвлэмэл эсвэл цахим) мэдээлэл өгөхөө анхаарч үзэх ёстой.

Адал явдалт аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч нар үйл ажиллагааны (жишээ нь хэлний бэрхшээл эсвэл шуугиан) түршид адал явдалт аяллын удирдагчийн зааврыг оролцогчид зөв ойлгосон эсэхийг баталгаажуулахын тулд харилцааны эрсдлүүдийг тодорхойлж хариу арга хэмжээ авах ёстой.

ТАЙЛБАР: Үйл ажиллагааны явцад харилцааны эрсдэлийн хариу арга хэмжээнд жишээлбэл тэмдэг, гарын дохио зангаа болон шүгэл ашиглах зэрэг орно.

## **4 Адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагаа эхлэхээс өмнө өгөх мэдээлэл**

### **4.1 Үйл ажиллагаа эхлэхээс өмнөх мэдээллийн зорилго**

Энэхүү дэд хэсэгт адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагааны захиалга авахаас өмнө өгөх мэдээллийг тоймлон харуулна.

Боломжит оролцогчдод үйл ажиллагаанд оролцох талаар мэдээлэлтэй сонголтууд өгч, үйл ажиллагааг нь эхлүүлэх боломжийг олгох үүднээс мэдээллийг өгөх ёстой.

Адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагаа нь угаасаа эрсдэлд ордог тул үйл ажиллагааны захиалга авахаас өмнө чухал эрсдлийн эх үүсвэр, холбогдох аюулгүй байдлын шаардлагыг заасан мэдээллийг өгөх ёстой.

## **4.2 Урьдчилсан захиалгын мэдээлэл**

### **4.2.1 Үйлчилгээ үзүүлэгч**

Урьдчилсан захиалгын мэдээлэлд адал явдалт аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчийн тухай дараахь зүйлүүд байх ёстой. Үүнд:

- a) нэр, хууль ёсны нэр, эрх зүйн байдал, холбоо барих хаяг (хаяг, утасны дугаар, имэйл хаяг) болон ажлын цаг;
- b) хэрэв адал явдалт аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь ямар нэгэн стандарт мөрддөг бол уг үйлчилгээ үзүүлэгч нь гэрчилгээжсэн эсэх, хэрэв гэрчилгээжсэн бол гэрчилгээ олгогч нь итгэмжлэгдсэн байдал;
- c) бусад холбогдох зөвшөөрөл, мэргэшсэн байдал.

### **4.2.2 Адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагаа**

Адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагааны талаархи урьдчилсан захиалгын мэдээлэлд дараахь зүйлийг багтаах ёстой. Үүнд:

- a) адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагааны тодорхойлолт, бүрдэл хэсгүүд болон үнэ;
- b) оролцогчдын хамгийн их болон бага тоо, удирдагчдын болон ажилчдын тоо;
- c) захиалж буй адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагааны хүрээнд үзүүлж буй бүрэлдэхүүн хэсэг үйлчилгээ, ж.нь:
  - 1) оролцогчдод санал болгосон тээврийн хэрэгслийн төрөл, тав тухтай байдлын зэрэг, хэрэв гуравдагч талын үйлчилгээ үзүүлэгч бол тэдний тодорхойлолт;
  - 2) байр сууцны төрөл, стандарт болон тэдгээрийн үйлчилгээнүүд, жишээлбэл амралт чөлөөт цагийн үйлчилгээ орчин нөхцөл, ариун цэврийн өрөөний зохион байгуулалт;
  - 3) хоол хүнсний хангамж, тусгай хоолны дэглэмийн нөөц ороод;
  - 4) тоног хэрэгслийн хангамж;
  - 5) хэрэв шаардлагатай бол бартаатай газарт тоног хэрэгслийг зөөвөрлөх боломж.
- d) адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагааны хүндрэлийн түвшин (шалгуурын тайлбартайгаар); хүндрэлийн түвшинг үнэлэхдээ дараах хүчин зүйлсийг тооцох ёстой:
  - 1) оролцогчоос шаардагдах бие бялдрын чийрэгжилт болон сэтгэл зүйн тодорхой түвшин ;
  - 2) үйл ажиллагааны үргэлжлэх хугацаа – өдөр тутмын болон бүх аяллын ;
  - 3) шаардагдах мэдлэг, ур чадварууд ;
  - 4) хүлээн зөвшөөрөгдсөн тусгай ур чадварын шаардлага;
  - 5) цаг агаарын урьдчилсан нөхцөл байдлууд ;
  - 6) хамрагдах газар нутгын газрын байдлаас үүссэн бэрхшээлүүд;
  - 7) шаардлагатай тохиолдолд, хүндрэлийн түвшин болон шалгуурын тайлбар;
- e) адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагааны хөтөлбөр:



- 1) Байршил (үүд);
  - 2) өөр газруудад очих, ирэх төлөвлөгөөт цагууд;
  - 3) үйл ажиллагааны/үйл ажиллагаануудын үргэлжлэх төлөвлөгөөт хугацаа;
  - 4) чөлөөт цагийн үргэлжлэх хугацаа;
- f) яаралтай түслэмжийн бэлэн байдал;
  - g) тусгай хэрэгцээт хүмүүс, хүүхэд эсвэл ахмадуудад зориулсан хэрэгслийн бэлэн байдал;
  - h) олон өдрийн үйл ажиллагаанд оролцогчид нь өсвөр насныхан байгаа тохиолдолд, тэдний тоо, хүйс болон удирдагчдын үүрэг, бусад дагалдан яваа хүн, жишээ нь эцэг эх;
  - i) жишээ нь нас, хүйс, эсвэл чадвараар ялгаатай тодорхой бүлгийн хүмүүст тусгайлан зориулсан адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагаануудын тохиромжтой байдлын талаар мэдээлэл;
  - j) тухайн нутгийн улс төрийн нөхцөл байдал, зан заншлын дэлгэрэнгүй мэдээлэл ;
  - k) орон нутгийн хууль тогтоомжийн дэлгэрэнгүй мэдээлэлүүд, тухайлбал:
    - 1) тусгай хамгаалалттай газр нутгуудад хүний үл мөрийг багасгах зорилгоор тогтоосон зочдын тооны хязгаарлалт;
    - 2) ил гал түлэх эсвэл саван зэрэг байгал орчны тэнцвэрт байдлыг алдагдуулж болзошгүй бүтээгдэхүүний хэрэглээг хязгаарласан байдал.

#### 4.2.3 Гэрээ

Адал явдалт аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч ба оролцогчдын хооронд байгуулсан гэрээний талаархи урьдчилсан захиалганд дараахь мэдээллийг багтаах ёстой. Үүнд:

- a) адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагаанд юу багтсан болох;
- b) оролцогчтой холбоотой адал явдалт аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчдийн даатгал;
- c) оролцоход шаардагдах даатгал болон даатгалын боломж;
- d) цуцлалт, өөрчлөлт, зөрчилд хүргэж болзошгүй хүчин зүйлс;
- e) эрсдлийг хүлээн зөвшөөрөх байдал;
- f) үүрэг хариуцлагууд;
- g) санал гомдлын журмууд;
- h) сонгосон адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагааг багтаагаад гэрээг цуцлах журам.

#### 4.2.4 Оролцогч

Урьдчилсан захиалгын оролцогчид холбогдох мэдээлэлд дараахь зүйл багтах ёстой. Үүнд:

- a) үйл ажиллагаа эхлэхээс өмнө адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагаа болох газруудад аливаа сургалт, чиг баримжаа олгох, мэргэших байлаар дадлагажих талаар тайлбар;
- b) вакцин, тарилга, урьдчилан сэргийлэх эм зэрэг эрүүл мэндийн шаардлагууд;
- c) адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагаанд аюулгүй байдлыг хангаж оролцоход шаардагдах оролцогчдод өгөх тоног хэрэгсэл эсвэл хувцас;
- d) оролцогчдоос шаардагдах өгөгдлийн мэдээлэл;
- e) дасгал сургуулилтын хамгийн доод түвшин.

### 5 Адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагааны явцад өгөх мэдээлэл

#### 5.1 Үйл ажиллагааны явцад өгөх мэдээллийн зорилго

Энэхүү дэд хэсэгт адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагаа захиалахаас үйл ажиллагаа дуусах хүртэл хүргэх мэдээллийг тусгасан болно.

Үйл ажиллагааны түршид хүргэх мэдээллийн зорилго бол:

- a) оролцогчдод тухайн үйл ажиллагаанд аль болох аюулгүй байдлыг хангах талаар тодорхой чиглэл өгөх, мөн
- b) оролцогчид үйл ажиллагааны чөлөөт цаг болон тэдний хийх хэрэгтэй буюу өөрчлөлтийн хариуд хийх боломжтой ямар нэг өөрчлөлтийг мэдэж байх явдал юм.

ТАЙЛБАР: Байгаль орчинд үүссэн цаг агаарын таагүй байдал, осол аваар, өвчин эмгэг, тоног төхөөрөмжийн эвдрэл зэрэг асуудлуудаас болж өөрчлөлтүүд гарч болзошгүй юм. Оролцогчид үүссэн асуудалд хариу өгөх боломжтой байхын тулд хангалттай мэдээлэлтэй байх нь чухал. Хариу үйлдлүүд нь тухайн эрсдэл, асуудлыг удирдахын тулд удирдагчын шинэ зааврыг хэрэгжүүлэх эсвэл оролцогчид үйл ажиллагааг орхих гэх мэт сонголтууд байж болно.

## **5.2 Үйл ажиллагааны явцад өгөх мэдээлэл**

Үйл ажиллагааны түршид өгөх мэдээлэл дор хаяж дараахь зүйлийг багтаах ёстой. Үүнд:

- a) үйл ажиллагааны үе шат бүхэнд юу болох болон оролцогч юу хийх хэрэгтэй тухай заавар ;
- b) үйл ажиллагааны тухай өмнө өгсөн мэдээлэлд гарсан аливаа өөрчлөлтүүд: жишээ нь эрсдлүүд, удирдлага, цаг хугацаа, чөлөөт цаг, байршил эсвэл тээвэрлэлт;
- c) аюултай тохиолдол болон онцгой байдлын үед авах хариу арга хэмжээ.

## **6 Адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагааны дараа өгөх мэдээлэл**

### **6.1 Үйл ажиллагааны дараа өгөх мэдээллийн зорилго**

Энэхүү дэд хэсэг нь адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагаа явагдаж дууссаны дараа өгөх мэдээллийг тусгасан болно.

Адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагааны дараа өгөх мэдээллийн зорилго нь үйл ажиллагааны түршид тохиолдсон аливаа асуудлын болзошгүй үр дагаврын талаар оролцогчдод зөв мэдлэг олгож, дүгнэх явдал юм.

### **6.2 Үйл ажиллагааны дараа өгөх мэдээлэл**

Оролцогчид нөлөөлж болох асуудал гарсан тохиолдолд адал явдалт үйл ажиллагааны дараа хамгийн багадаа дараахь мэдээллийг өгөх хэрэгтэй. Үүнд:

- a) асуудлын тодорхойлолт;
- b) асуудлын үр дагавар;
- c) тухайн асуудлын талаархи оролцогчид шаардлагатай нэмэлт мэдээлэл эсвэл үйл ажиллагаа.

Ном зүй

- [1] ISO 21101, Adventure tourism — Safety management systems — Requirements
- [2] ISO/TR 21102, Adventure tourism — Leaders — Personnel competence
- [3] ISO Guide 73:2009, Risk management — Vocabulary

Байгууллагаас Санал авах Төсөл